



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/344

Мандалговь

Цэрэг-спортын “Дөл” цогцолбор  
тэмцээнд оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30.1.17, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 12.1.1, 17 зүйлийн 17.1.1, Батлан хамгаалахын сайд аймгийн Засаг даргатай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний ажил үйлчилгээ 5.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2022 оны 09 дугаар сарын 02-ны өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах Цэрэг-спортын “Дөл” тэмцээн болохтой холбогдуулан аймгийн Политехникийн коллеж, ерөнхий боловсролын сургуулиудаас тэмцээнд оролцох ахлах ангийн сурагчдыг сонгон шалгаруулж, Цэрэг- спортын “Дөл” цогцолбор тэмцээнд батлагдсан удирдамжийн дагуу бэлтгэлийг 2022 оны 08 дугаар сарын 20-24-ний өдрүүдэд орон нутагт хангаж тэмцээнийг 08 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд “Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төв”-д зохион байгуулалтайгаар оролцуулсугай.

2. Тэмцээний бэлтгэл болон зохион байгуулалтай оролцох, арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж, батлагдсан удирдамж, заавар, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, хөдөлгөөний үеийн аюулгүй ажиллагааны болон бусад холбогдох дүрэм, журмыг сайтар мөрдүүлж, ажиллахыг Ажлын хэсгийн дарга (дэд хурандаа Ш.Гансүх)-т хариуцуулсугай.

3. Тэмцээний бэлтгэлийг хангуулж, оролцуулах, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

4. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах Цэрэг-спортын “Дөл” тэмцээний удирдамжийг нэгдүгээр, тэмцээний бэлтгэлийг хангах, үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, тэмцээнд оролцох /сурагч/ бүрэлдэхүүнийг гуравдугаар, арга хэмжээнд шаардагдах зардлыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

5. Арга хэмжээнд шаардагдах 9.108.000 (есөн сая нэг зуун найман мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Энхмарт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111152